

**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2019.04.30

№ ХЭХ 03/02

Улаанбаатар хот

2019 оны 04 сарын 30-ны өдөр 10:00 минут, мягмар гараг, Хан-Уул дүүргийн 3-р хороо, үйлдвэрийн гудамж, 21 тоот хаягт байрлах Гоёо ХХК-ийн төв байр, 1 дүгээр давхрын хурлын танхимд хуралдав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Сайн байцгаана уу. Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн амар амгаланг эрье. Өнөөдрийн хурлыг гүйцэтгэх захирал Ганбат захирлаар удирдуулаад явъя. Одоо хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийн дагуу хурлын ирц бүртгэлийн талаар тооллогын комиссын дарга Т.Солонго танилцуулна.

Тооллогын комиссын дарга Т.Солонго: Сайн байцгаана уу. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн танилцуулъя.

Хувьцаа эзэмшигчдийн энэ хуралд 16 хувьцаа эзэмшигч биеэр оролцож, нийт саналын эрх бүхий нийт хувьцааны 74,39 хувь болж байгааг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигч нар болон хурлын даргад мэдээлсүгэй. Ингэснээр хурлыг хүчин төгөлдөрт тооцож хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг үргэлжлүүлэхэд ирц хүрсэн байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Хурлын ирц бол хүчин төгөлдөр болсон байна. Тооллогын комиссоос тогтоол гарч байгаа юм байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Ч.Ванчин-Эрдэнийг томилсон боловч Хурлын дарга гадаадад томилолттой байгаа тул хурлыг Гүйцэтгэх захирал Ё.Ганбат даргалуулахаар ТУЗ-ийн дарга шийдсэн байна. Хурлын даргаас хурлын дэг дарааллыг танилцуулаад хурлыг эхэлцгээе.

Хурлын дэгийн дагуу

Санхүүгийн холбогдох ажилтан хуралд хоцорч ирэхээр болсон тул компанийн үйл ажиллагааг танилцуулаад хурлаа эхэлье.

Хурлын дарга Ё.Ганбат: Сайн байцгаана уу та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. 2018 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя. Асууж тодруулах зүйл байвал шууд шууд асуугаад явах боломжтой.

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах /Гүйцэтгэх захирал Е.Ганбат/ танилцуулав.

Компанийн эрхэм зорилго бол зах зээлд чанарын шаардлага хангасан өндөр чанартай үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж салбартаа манлайлах гэсэн зорилготой. МУ хэмжээнд ойролцоогоор 14 татваргүй барааны дэлгүүр ажилладаг. Энэ дэлгүүрүүдээс гол 8 9 нь онгоцны буудалд ажилладаг. Улирал улирлаар бараа татан авалтыг судалдаг. Бараа татан авалтаар 2018 онд 1-р явж байгаа. Манай компани 3 дэлгүүртэй. Чингис хаан ОУНБ-д нэг салбар нээж одоогоор 3 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Хөшигтийн хөндийд шинээр буудал баригдсан тэр дотор шинээр дэлгүүр нээх ажиллагаа МУ 49 хувь Япон улс нь 51 хувийг нь эзэмшээд менежмент явуулна гэсэн боловч одоо болтол шийдвэр гарахгүй байна. 7 сарын 1-д ЕС шинэ нисэхийг хүлээж авна гэсэн боловч одоогоор 2020

оны 3 сард авна гэсэн мэдээ байна. Шинэ нисэх дээр 8 9 дэлгүүрийг тендерт оруулаад шалгаруулна.

Татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь 2019 8 сар, 10 сар хүртэл байна. Хүчинтэй хугацаа дуусахад дахин тендерт зарлахад хугацааг сунгуулна. Хугацаа сунгахдаа компанийн туршлага үйл ажиллагааны зөрчил зэргийг харгалзан үзнэ. Төлөвлөгөөний биелэлт 45-50 хувиар буурч байгаа гэсэн үг юм. Энэ нь борлуулалтад нөлөөлж байна.

Татваргүй барааны дэлгүүрт тавигдах шаардлагаар манайх олон төрлийн бараа зардаг, хамгийн том талбайтай, 8 ажилтны машинаар зөөдөг, зардал өндөртэй түрээсийн зардалд 10 сая төгрөг төлж байна.

Гаалиас гаргасан шаардлагын дагуу 20 гаруй сая төгрөгийн камер бусад жижиг зардал гаргаж шинэчлэлт өөрчлөлтийг хийгээд байна. Алтан булаг худалдааны төв нэг хүн нэмж 3 хүн болж байгаа. Зуны цагийн хуваарийн дагуу нэг хүн нэмж байгаа.

ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн хараат гишүүд "Таван Богд Трейд" ХХК-ийн захирал Ц.Баатарсайхан, Д.Хулан, Ц.Оргилболд, Ц.Оюунцэцэг, Ц.Цэцэнхүү, Ч.Ванчин-Эрдэнэ гэсэн 6 гишүүнтэй байна. Хараат бус гишүүд Я.Пүрэв, Д.Байгальмаа, Ж.Мягмарсүрэн нар, Гүйцэтгэх захирал Е.Ганбат би өөрөө, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа байна.

Алтанбулаг шалган нэвтрүүлэх төвийн 1-р давхарт байрладаг тэнд байрлах талбай бол 46,7 м2 талбайтай үүнээс 2 складтай. Гол орлого олдог сизон нь 6-10 сар.

Төмөр замдаа бол дэлгүүр нэг складтай үйл ажиллагаа явуулдаг. Оны эхнээс гаалийн байцаагч камераар хянаж байгаа учраас борлуулалт 50 хүртэл хувь буурсан байна.

Хувьцаа эзэмшигч: Нэг зүйл тодруулъя төмөр зам дээр орлого буурсан байна. Хяналттай ямар холбоотой вэ?

Хурлын дарга Ё.Ганбат: Дотоодын үйлчлүүлэгч нар маш их худалдан авалт хийдэг байсан гаалийн газраас камер хянаад эхлэхлээр орлого буурч байгаа юм. Одоо бол зөвхөн билет харж борлуулалт хийдэг болсон. Яг л ажлын цагт нь тааруулж ажиллана гаалийн байцаагч тэр цагт нь хянаж байгаа. Ганц манай дэлгүүр биш бүх татваргүй барааны дэлгүүрийг хянаж байгаа.

Урьдчилсан байдлаар нөхцөл байдлыг хувьцаа эзэмшигч нарт танилцуулж байгаа нь зөв гэж бодож байна.

Манай дэлгүүр энэ жилээс монгол гэсэн брэндүүдийг дэлгүүртэй байршуулж зарж эхэлсэн байгаа. Монгол гайгүй брэндүүдийг шалгаруулаад зарж байна. Шоколад бол маш сайн зарагдаж байгаа. Өрсөлдөх чадварын хувьд манайх бол татваргүй барааны дэлгүүрийн хувьд 1 2 л явдаг.

Хувьцаа эзэмшигч: тусгай зөвшөөрлийн хугацааг хэдэн жилээр авдаг юм бол.

Хурлын дарга Ё.Ганбат: 3 жил. Тендерт 2 сарын өмнөөс нь орж эхэлнэ. Манай тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж байна. Бид нар дэлгүүрээ үргэлжлүүлэн ажиллуулах сонирхолтой байна гэж хүсэлтээ гаргана. Гаалиас энэний дагуу тендер зарлана.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Хувьцааны өсөлт буурлын талаар мэдээлэл хүргэе Та бүхэн ерөнхийдөө өсөлт бууралтыг мэдэж байгаа байх. 2016 оны Таван Богд групп маань худалдаж авснаас хойш хувьцааны ханш өсөлттэй байна. 2018 оны 1680 ширхэг хувьцаа арилжаалагдсан байна. Эндээ нэгж хувьцааны дундаж ханш нь 97 мянган төгрөг байна. Өнөөдрийн байдлаар хувьцааны дундаж ханш 110 мянган төгрөг байна.

Мөн ногдол ашгийнхаа талаар мэдээллийг танилцуулаад явъя. 2018 онд 10 мянган төгрөг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашгийг бид өмнөх шигээ компани дээрээ олгож байгаа. Нийт 39 хувьцаа эзэмшигч ногдол ашиг авсан байна. 2018 онд тараасан

ногдол ашгийн хэмжээн нь 538 сая төгрөг байна. Ногдол ашгаа аваагүй хүн байдаг тэр маань санхүү бүртгэл дээрээ ногдол ашгийн өглөгөөр бүртгэлтэй явж байгаа.

Зарим брокерын компаниуд компанийн талаар буруу мэдээлэл өгдөг зүйл анзаарагддаг. Таны хувьцаа бараг цаас болсон гэх мэтээр ярьж тайлбарладаг зүйл байдаг. Та хувьцаагаа манай компанид зараад мөнгөө олж аваад яваа гэсэн саналыг тавьсны дагуу зарсан зүйл байгаа юм байна лээ. Хувьцаа эзэмшигч нар маань өөрсдөө хариуцлагатай хандаад мэдээллээ зөв эх сурвалжаас авч, ногдол ашгаа аваад явж байх ёстой.

2018 оны ногдол ашгийг маргаашаас буюу 5 сарын 1-ны өдрөөс тарааж эхэлж байна. Ногдол ашгаа авахдаа иргэний үнэмлэх дансны хуулга, ногдол ашиг авах өргөдөл гарган авна. Компани энд байрлаж байгаа. Хувь хүн бол ногдол ашгийн 10 хувийн татварыг нь суутгаж авдаг. Гадаадын этгээдүүд бол хуулийн дагуу 20 хувь суутгаж авна. Компаниас бол авахгүй компани өөрөө орлогоо тайлагнаад явна. 99103919 Энхгэрэл ерөнхий нягтлан бодогчийн утас.

Хувьцаа эзэмшигч: шууд дансаар нь ногдол ашгийг олгож болохгүй юм уу.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Энэ нь өөрөө санхүүгийн анхан шатны баримт бүрдүүлж олгодог юм. Тухайн мөнгийг гаргасан баримт болж компанид үлддэг учраас заавал өргөдөл авдаг. Брокерын дансны хуулга байж болно.

Хувьцаатай холбоотой тодруулах зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч: Нэг зүйл асууя. Нийт хэдэн ширхэг хувьцаа байна. Одоогийн байдлаар хэдэн хүн эзэмшиж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: 65,362 ширхэг хувьцаа байна. Нийт 310 гаруй хүн эзэмшиж байна.

Хувьцаа эзэмшигч: Жил болгон ашгийнхаа тал хувийг тарааж байгаа. Энэ цаашид нэмэгдэх үү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Ногдол ашиг маань борлуулалтын орлогоос хамаарч байгаа. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд төлөвлөгөө биелсэн тул ногдол ашиг тараасан. Ашиг орлого хэвийн бол ногдол ашиг хуваарилна.

Хувьцаа эзэмшигч: хувьцаа хуваах тал дээр ойрын хугацаанд төлөвлөсөн зүйл байхгүй гэж ойлголоо.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Ойрын хугацаанд хуваах асуудал байхгүй, яригдсан зүйл алга байна.

Хувьцаа эзэмшигч: Өнгөрсөн онд борлуулалт маань 49 хувь өссөн мөртлөө ашиг маань 29 хувь өссөн байх юм ямар учиртай вэ?

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Санхүүгийн тайланг танилцуулъя.

“Жуулчин Дютти Фрий” ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл: Борлуулалт 49 хувь өссөн, Ашиг маань 29 хувь өссөн шалтгаан нь нисэх салбар 6 сард нээгдээд хагас жил ажилласан. Энэ онд бүтэн ажилласан болохоор маркетингийн зардал өссөн байгаа. Ерөнхий удирдлагын зардал өссөн бүтцийн өөрчлөлт орсон, тэгээд ашигт өөрчлөлт орсон. Балансын хувьд эргэлтийн хөрөнгө 17 онд 2,2 тэрбум байсан бол 18 онд 4,1 тэрбум буюу 89 хувийн өсөлттэй байна. Эргэлтийн бус хөрөнгө нь 232 сая байсан бол 290 сая болж 25 хувийн өсөлттэй, нийт хөрөнгө 2.2 тэрбумаас 4,4 тэрбум буюу 82 хувийн өсөлттэй, ашигтай жил болж өнгөрсөн.

2018 оны санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан жагсаалтад бүртгэлтэй “Эм Жи Эм Ди Аудит” ХХК-тай гэрээ байгуулан 2018 оны 12-р сарын 31-ны байдлаар санхүүгийн тайланд Хараат бус аудиторын дүгнэлт гаргуулсан болно. Дүгнэлтэд 2018 оны 12-р сарын 31-ний санхүүгийн тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон

жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлгэсэн.

Та бүхэн хүсвэл санхүүгийн тайлантай танилцаж болно.

Хурлын дарга Ё.Ганбат: Гол борлуулалт төмөр замаар дамждаг байсан. Нисэх дээр талбай өөрчилсөн.

Хувьцаа эзэмшигч: Өнгөрсөн онд өр төлбөр нэмэгдсэн тэр юутай холбоотой вэ?

“Жуулчин Дютри Фрий” ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл: Замд яваа бараа 1 тэрбум орчмын барааны төлбөр өглөгөөр бүртгэгдсэн. Замд яваа учраас орлогод аваагүй. 120 тонн бараа ирсэн. Монгол харилцагч нараас авсан бараа дэлгүүрт байгаа бол өглөгөөр бүртгэгдэж байгаа.

Хувьцаа эзэмшигч: Би Баян-Өлгий аймгаас яваа юм. Баян-өлгийн хүмүүсийн хувьцааг итгэмжлэлээр авч байсан. Анх 92 онд үнээр ягаан тасалбарыг худалдаж асан юм газар сүлжмэл компанийн хувьцааг. 2008 онд засгийн газрын тогтоол гарсан тэрний дагуу би Казакстан улс руу нүүж явсан хүмүүсээс итгэмжлэл хийлгээд хувьцаагаа зарсныг авж байсан юм. Тэгтэл танай компанийн хувьцаа бүр өсөж ногдол ашиг тарааж байсан юм байна. Миний анх бодож байснаас шал өөр байсан. Би Таван Богд Брокерын компани нь бидний хувьцааг 40 мянган төгрөгөөр худалдаад авчихдаг байсан. Тэгээд ямар их ногдол ашиг хувьцаагаа алдчихлаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Хол газраас хуралдаа оролцож санал хэлсэнд баярлалаа. 2018 оны ТУЗ-өөс төлөвлөгөөгөө 18 хувиар биелүүлж амжилттай сайн ажилласан гэж дүгнэсэн байгаа. 2019 оны зорилтод шинэ нисэх буудал тусгай зөвшөөрөл анхаарах, дэлгүүр стандартад нийцсэн байх, хэрэгдэгчдэд өргөн хүрээнд бараа борлуулахад чиглэсэн, арга хэмжээ үйл ажиллагаа авч ажиллахыг төлөвлөсөн байна. Энэхүү дүгнэлтийг бид бүхэн хурлаараа батлах асуудлын нэг байгаа. Та бүхэнд тараасан саналын хуудсаар саналаа бөглөж өгнө үү. Саналын хайрцагт саналаа хийнэ үү.

Мөн санхүүгийн төлөвлөгөөний дагуу дараагийн асуудлаа ярья. 2019 оны төлөвлөгөөгөө танилцуулъя.

“Жуулчин Дютри Фрий” ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл: 2018 онд 5,7 тэрбумын борлуулалтын орлоготой ажилласан бол 2019 онд 6 тэрбумын борлуулалтын орлоготой ажиллана гэж төлөвлөсөн байгаа. Маркетинг борлуулалтын зардал нь 594 сая гэж төлөвлөсөн. Ерөнхий удирдлагын зардал 495 сая, нийт цэвэр ашиг нь 1,3 тэрбум байна. 5-10 хувийн өсөлттэй ажиллана гэж төлөвлөж байна.

Хувьцаа эзэмшигч: Энэнд хөшигтийн хөндий орсон юм уу.

Хурлын дарга Ё.Ганбат: Тооцож оруулсан байгаа.

“Жуулчин Дютри Фрий” ХК-ийн ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл: Нисэх салбараа бүтэн ажиллана гэж тооцон 1,7 тэрбум оруулсан байгаа. Хэрвээ бид хөшигтийн хөндийд ашигтай байрлалд тендерт шалгараад орчих юм бол одоо 6,30-р төсөвтөө тодотгол хийж өгнө гэсэн үг юм.

Хувьцаа эзэмшигч: Компанийн үйл ажиллагааг асар өндөр өсөлттэй барьж байгаа. Маркетингийн сурталчилгаа байршуулж байгаа юу. Жишээ нь дээр байрладаг шатны хажууд.

Хурлын дарга Ё.Ганбат: Шатны хажууд тавсан юм 2 сая төгрөг.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Саналын хуудаснуудаа бүгд өгсөн үү?

Хурлын дарга Ё.Ганбат: Өөр санал байхгүй бол компани маань өнгөрсөн онд урдаа тавсан зорилгодоо хүрсэн гэж үзэж байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа: Тооллогын комиссоос 2 саналын дүнгээ нэгтгэн та бүхэнд танилцуулна.

Тооллогын комиссын дарга Т.Солонго: Нийт өнөөдрийн хуралд 19 хувьцаа эзэмшигч оролцсоноос 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг батлахаар шийдвэрлэсэн байна. Саналын 2-р хуудас буюу компанийн 2019 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг батлах саналын хуудсыг 100% зөвшөөрсөн батлахаар шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Баярмаа:

Хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд оруулсан 2 асуудлаар хэлэлцсэн асуудлыг 100 хувь дэмжигдсэн учраас тогтоолын төслийг батлахаар тогтоолын төсөл батлагдаж байна.

Ингээд өнөөдрийн хурал өндөрлөж байна хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хурлыг хаав.

Хурлын дарга :



Ё. Ганбат

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ын нарийн бичгийн дарга Ч. Баярмаа

2019 оны 04 сарын 30-ны өдрийн 11 цаг 35 минутад дуусав.

